ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: О.Хосбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10
3. Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....11
3.4 Материаллаг байдал ....11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....13
3.8 Аудитын гол асуудал ....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
4. Аудитын илрүүлэлт ....15
4.1 Залруулсан алдаа .... 15
4.2 Төлбөрийн акт .... 15
4.3 Албан шаардлага .... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУБШУ | Монгол Улсын боловсрол шинжлэх ухаан |
| ТЗШ | Тусгай зориулалтын шилжүүлэг |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/933
танай ________ -ны № ________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ТУНГАЛАГ ТАНАА

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн байдлын тайлантай өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн нийт 2.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусламж санхүүжилтийн орлого, мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 264.0 сая төгрөгөөр зөрүүтэй боловч орон нутгийн төсвөөс авах авлага, өглөгийн тооцоогүй,
3. Төсвийн санхүүжилтийн нийт орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогын нийлбэр нь мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй,
4. Орон нутгийн төсвийн санхүүжилт төсвийн тайланд 0.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн орлого зарлагын ангиллыг зөрүүлсэн зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын алдаа зөрчил түгээмэл тархсан байна.
5. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмжийн эцсийн үлдэгдлийг 2.0 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэйгээр илэрхийлсэн.
6. Байгууллагын дотоод хяналт сул, нягтлан бодох бүртгэл алдаатай, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодогч мэргэжлийн бус, нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS программтай хэдий ч хагас дутуу ашиглаж, excel программаар санхүүгийн тайланг гаргасан зэрэг нь тооцооллын болон нягтлан бодох бүртгэл дутуу хөтөлсөн алдаа гарах өндөр эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

Эдгээр алдаа зөрчил нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж,

стандарт, дүрэм, журам, заавapт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцээгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын алдаа зөрчил түгээмэл байгаа нь УСНББОУС 28, 29, 30, санхүүгийн тайлан үнэн зөв байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **74,621,873.58** | **41,535,004.07** |
| **33** | **АВЛАГА** | **628,450.00** | **231,839.51** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 231,839.51 |
| **335** | **Бусад авлага** | **628,450.00** | **00.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 628,450.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **73,993,423.58** | **41,303,164.56** |
| **351** | **Түүхий эд материал** | **2,322,350.00** | **2,144,366.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 911,800.00 | 625,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,410,550.00 | 1,519,366.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 14,715,848.50 | 3,610,505.10 |
| **354** | **Хангамжийн материал** | **56,955,225.08** | **35,548,293.46** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,846,500.00 | 362,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,960,300.00 | 26,308,850.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,606,000.00 | 6,934,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,686,920.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,323,105.08 | 1,410,843.46 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 532,400.00 | 532,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,082,110,976.94** | **1,043,736,716.09** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,082,110,976.94** | **1,043,736,716.09** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,058,382,976.94** | **1,020,008,716.09** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,112,189,086.00 | 1,112,189,086.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -88,899,265.59 | -115,716,813.03 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 56,092,640.00 | 40,287,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -35,381,287.01 | -26,761,508.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,703,017.61 | 21,122,227.61 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,128,862.31 | -11,887,269.62 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,177,562.00 | 858,632.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -25,496,473.96 | -355,087.92 |
| 39217 | Ном | 3,126,560.20 | 272,450.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **23,728,000.00** | **23,728,000.00** |
| 39301 | Програм хангамж | 825,000.00 | 00.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -825,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,728,000.00 | 23,728,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,156,732,850.52** | **1,085,271,720.16** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,156,732,850.52** | **1,085,271,720.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,156,732,850.52** | **1,085,271,720.16** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 94,534,205.00 | 94,534,205.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 94,534,205.00 | 94,534,205.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **972,574,676.44** | **901,113,546.08** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 972,574,676.44 | 972,574,676.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -71,461,130.36 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 89,623,969.08 | 89,623,969.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,156,732,850.52** | **1,085,271,720.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **331,863,975.10** | **284,516,566.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,108,475.10** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **10,108,475.10** | **00.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,108,475.10 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 10,108,475.10 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,772,700.00** | **20,487,366.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **00.00** | **50,000.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 50,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 300,982,800.00 | 264,029,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **918,166.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 918,166.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **20,772,700.00** | **19,519,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,772,700.00 | 19,519,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **334,444,889.92** | **351,172,790.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **334,444,889.92** | **351,172,790.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **318,755,605.76** | **340,327,881.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **213,014,262.00** | **223,009,425.64** |
| 210101 | Үндсэн цалин | 213,014,262.00 | 223,009,425.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,166,065.73** | **18,036,463.11** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,772,073.73 | 18,036,463.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,136,369.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,709,095.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 404,366.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,144,162.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,764,094.84** | **12,541,629.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,174,094.84 | 1,996,729.85 |
| 210302 | Түлш, халаалт | 12,840,000.00 | 9,622,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 750,000.00 | 922,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,616,540.00** | **29,320,465.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,488,740.00 | 333,912.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,190,200.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 210,000.00 | 187,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 178,600.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 48,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,501,000.00 | 27,799,053.40 |
| **2105** | **Нормативт зардал** | **11,953,444.48** | **10,671,594.62** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 743,200.00 | 1,487,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,210,244.48 | 9,183,794.62 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,211,000.00** | **5,609,620.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,211,000.00 | 5,609,620.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **178,600.00** | **156,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 178,600.00 | 156,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **940,000.00** | **550,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 640,000.00 | 250,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **35,911,598.71** | **40,432,483.14** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 177,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 419,500.00 | 3,837,688.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 35,315,098.71 | 36,594,795.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,689,284.16** | **10,844,908.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **440,000.00** | **00.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 440,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,673,379.00** | **10,068,038.74** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,673,379.00 | 10,068,038.74 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **3,575,905.16** | **776,870.15** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,575,905.16 | 776,870.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-2,580,914.82** | **-66,656,224.65** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **4,804,905.71** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 4,804,905.71 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **-4,804,905.71** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-2,580,914.82** | **-71,461,130.36** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **C01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,534,205.00** | **975,155,591.26** | **1,159,313,765.34** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **94,534,205.00** | **975,155,591.26** | **1,159,313,765.34** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -2,580,914.82 | -2,580,914.82 |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,534,205.00** | **972,574,676.44** | **1,156,732,850.52** |
| **D01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,534,205.00** | **972,574,676.44** | **1,156,732,850.52** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **94,534,205.00** | **972,574,676.44** | **1,156,732,850.52** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -71,461,130.36 | -71,461,130.36 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,534,205.00** | **901,113,546.08** | **1,085,271,720.16** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **321,755,500.00** | **284,516,566.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **321,755,500.00** | **284,516,566.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 300,982,800.00 | 264,029,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **918,166.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 918,166.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **20,772,700.00** | **19,569,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,772,700.00 | 19,569,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **313,185,500.00** | **282,360,566.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **313,185,500.00** | **282,360,566.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **297,496,215.84** | **271,515,657.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **211,505,947.00** | **215,673,735.96** |
| 210101 | Үндсэн цалин | 192,143,646.00 | 159,682,697.55 |
| 210102 | Нэмэгдэл | 9,919,312.00 | 50,590,861.55 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 9,442,989.00 | 5,400,176.86 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **28,604,157.00** | **25,603,992.30** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,940,657.00 | 17,462,671.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,165,900.00 | 2,053,641.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,732,700.00 | 1,572,952.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 433,100.00 | 407,443.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,331,800.00 | 4,107,282.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,924,094.84** | **14,869,629.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,174,094.84 | 1,996,729.85 |
| 210302 | Түлш, халаалт | 12,000,000.00 | 11,950,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 750,000.00 | 922,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,795,800.00** | **2,374,900.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 464,200.00 | 187,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 210,000.00 | 187,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 178,600.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,143,000.00 | 999,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,328,717.00** | **7,864,699.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,071,200.00 | 968,166.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,443,317.00 | 6,271,533.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,814,200.00 | 625,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,772,700.00** | **1,922,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 500,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,272,700.00 | 1,922,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **178,600.00** | **156,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 178,600.00 | 156,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **800,000.00** | **550,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 250,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,586,200.00** | **2,499,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 515,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,071,200.00 | 2,499,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,689,284.16** | **10,844,908.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **440,000.00** | **00.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 440,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,673,379.00** | **10,068,038.74** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,673,379.00 | 10,068,038.74 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **3,575,905.16** | **776,870.15** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,575,905.16 | 776,870.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,570,000.00** | **2,156,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,570,000.00** | **2,156,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,570,000.00** | **2,156,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **8,570,000.00** | **2,156,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,570,000.00 | 2,156,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,570,000.00** | **-2,156,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 283,598,400.0 | 272,753,491.1 | 10,844,908.9 | 96.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 283,598,400.0 | 272,753,491.1 | 10,844,908.9 | 96.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 283,598,400.0 | 272,753,491.1 | 10,844,908.9 | 96.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,029,400.0 | 215,673,736.0 | 1,355,664.0 | 99.4 |
| 210101 | Үндсэн цалин | 149,685,800.0 | 159,682,697.6 | -9,996,897.6 | 106.7 |
| 210102 | Нэмэгдэл | 52,580,600.0 | 50,590,861.6 | 1,989,738.5 | 96.2 |
| 210104 | Урамшуулал | 14,763,000.0 | 5,400,176.9 | 9,362,823.1 | 36.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,299,000.0 | 25,603,992.3 | 3,695,007.7 | 87.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,617,800.0 | 17,462,671.8 | 3,155,128.2 | 84.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,170,300.0 | 2,053,641.2 | 116,658.8 | 94.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,736,200.0 | 1,572,953.0 | 163,247.0 | 90.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 434,100.0 | 407,443.9 | 26,656.1 | 93.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,340,600.0 | 4,107,282.4 | 233,317.6 | 94.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,646,500.0 | 14,869,629.9 | 776,870.2 | 95.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,296,500.0 | 1,996,729.9 | 299,770.2 | 86.9 |
| 210302 | Түлш, халаалт | 12,000,000.0 | 11,950,000.0 | 50,000.0 | 99.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,350,000.0 | 922,900.0 | 427,100.0 | 68.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,531,100.0 | 2,530,900.0 | 200.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 187,500.0 | 187,500.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 187,500.0 | 187,500.0 | 00.0 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 156,200.0 | 156,000.0 | 200.0 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 999,900.0 | 999,900.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,495,200.0 | 6,946,533.0 | 4,548,667.0 | 60.4 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,500.0 | 50,000.0 | 12,500.0 | 80.0 |
| 210502 | Хоол, хүнс | 10,807,700.0 | 6,271,533.0 | 4,536,167.0 | 58.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 625,000.0 | 625,000.0 | 00.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,922,700.0 | 3,922,700.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,922,700.0 | 3,922,700.0 | 00.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 156,200.0 | 156,200.0 | 00.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 156,200.0 | 156,200.0 | 00.0 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 550,000.0 | 550,000.0 | 00.0 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.0 | 250,000.0 | 00.0 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.0 | 300,000.0 | 00.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,968,300.0 | 2,499,800.0 | 468,500.0 | 84.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 468,500.0 | 00.0 | 468,500.0 | 00.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,499,800.0 | 2,499,800.0 | 00.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 283,598,400.0 | 272,753,491.1 | 10,844,908.9 | 96.2 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 264,029,200.0 | 253,961,161.3 | 10,068,038.7 | 96.2 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 264,029,200.0 | 253,961,161.3 | 10,068,038.7 | 96.2 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 19,569,200.0 | 18,792,329.9 | 776,870.1 | 96.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 19,569,200.0 | 18,792,329.9 | 776,870.1 | 96.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 22.00 | 00.0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | 00.0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | 00.0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **918,166.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **918,166.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **918,166.00** |
| **2105** | **Норматив зардал** | 918,166.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 918,166.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 918,166.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 918,166.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 918,166.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хатгал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ахлах аудитор О.Хосбаяр, нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг нь “Хүүхдийн хөгжил сурах үйлийг дэмжих, агуулгын хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг дэмжих” эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил сурах үйлийг дэмжиж агуулгын хоцрогдлыг нөхөн ажиллахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг хангаж, сургалт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

- Цар тахлын үеийн онцгой нөхцөл байдлын үед ажиллах горимыг мөрдөн, нөхцөл байдлыг даван туулахад багш ажилтан, хүүхэд эцэг эхэд дэмжлэг үзүүлнэ.
- Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар эцэг эх ОНБ-тай хамтран ажиллах, эрүүл аюулгүй орчинд хөгжих боломжийг нэмэгдүүлэн ажиллах
- Хөдөө багт эцэг эхийн асрагаанд байгаа 5 настай хүүхдүүдэд СӨБ-д 100% хамруулан ЕБС-д бэлтгэн оруулах үйл ажиллагааг зохион байгуулах.
- Сургалтын гадаад дотоод орчин, багш ажилчдын ая тухтай ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 сарын 18-ний 450 дугаар тогтоол 2,475 төгрөгөөр тогтоосныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 334.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68.9 сая төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлтүүдтэй холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Дансны авлага | 0.6 | 0.2 | (0.4) |
| Бараа материал | 74.0 | 41.3 | (32.7) |
| Үндсэн хөрөнгө | 1,082.1 | 1,043.7 | (38.4) |
| **Нийт хөрөнгө** | **1,156.7** | **1,085.3** | (71.5) |
| Хуримтлагдсан үр дүн | 972.6 | 901.1 | (71.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,156.7** | **1,085.3** | (71.5) |

Мөнгөн хөрөнгө данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.2 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь өмнөх оны авлага болох “Монос Хөвсгөл” ХХК-ийн 0.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, Нийгмийн даатгалаас 0.2 сая төгрөгийн авлага авахаар тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32.7 сая төгрөгөөр буурч 41.3 сая төгрөг болсон байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь:

- Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулах зорилгоор 58.9 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.
- ИТХ-ын №60 дугаар тогтоолоор 0.9 сая төгрөгийн бараа материалыг акталсан.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 38.4 сая төгрөгөөр буурч 1,043.7 сая төгрөг болсон байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь:

- ИТХТ-ийн 60 тоот тогтоолоор, машин тоног төхөөрөмж 15.0 сая төгрөг, тавилга эд хогшил 7.6 сая төгрөг, номын фонд 3.0 сая төгрөгийн биет хөрөнгийг акталж устгасан.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 901.1 сая төгрөг болж 71.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 325.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 20.7 сая нийт 346.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 325.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 20.7 сая төгрөг нийт 346.6 сая төгрөгийн санхүүжилт баталсан бол тайлант хугацаанд төсөвт 1 удаа өөрчлөлт орж, төсвийг анхны төсвийг бууруулан 283.6 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: төсөвт зардлын санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээс 264.0 сая төгрөг болгон бууруулж, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 19.6 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээнд зориулан нийт зардлын 253.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 19.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөснөөс гүйцэтгэлээр 272.5 сая төгрөг буюу 96.2 хувьтай байгаа ба цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1.4 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ 3.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.7 сая төгрөг, норматив зардал 3.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.5 сая төгрөгийн зардал тус тус хэмнэж нийт 10.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: Хөтөлбөр: 71801 Сургуулийн өмнөх боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх
81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах
80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал
81807 – Цэцэрлэгийн хүүхдийн хоол

Хүснэгт 2. Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

| Хөтөлбөр | арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 71801 | 81834 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх | 150.4 | 145.5 | 4.9 | 96.7 |
| 71801 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 102.8 | 102.2 | 0.6 | 99.4 |
| 71801 | 80109 | ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 19.6 | 18.8 | 0.8 | 95.9 |
| 71801 | 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 10.0 | 6.3 | 3.7 | 63.0 |

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 91.2 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

МУБШУ-ны сайдын 2021 оны 8 сарын 12-ны өдрийн А/279 тоот тушаал, эрхлэгчийн 2021 оны 9 сарын 20-ны өдрийн А/47 тоот тушаалаар 0.9 сая төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар төсвийн танилцуулга дутуу байна.

Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр  хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан байна.Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар дараах алдаа, зөрчил нийтлэг байна. Үүнд:

Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн байдлын тайлантай өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн нийт 2.7 ая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусламж санхүүжилтийн орлого, мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 264.0 сая төгрөгөөр зөрсөн, шалгагдагч байгууллага төсвөөс авах авлага, өглөг байхгүй, төсвийн санхүүжилтийн нийт орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогын  нийлбэр нь мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 10.0 сая төгрөгөөр зөрсөн, орон нутгийн төсвийн санхүүжилт төсвийн тайланд 0.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн орлого зарлагын ангиллыг зөрүүлсэн зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын алдаа зөрчил түгээмэл тархсан байна.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмжийн эцсийн үлдэгдлийг - 2.0 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэйгээр илэрхийлсэн.

Байгууллагын дотоод хяналт сул, нягтлан бодох бүртгэл дутуу хөтөлсөн алдаатай, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нягтлан бодогч мэргэжлийн бус, нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS программтай хэдий ч хагас дутуу ашиглаж, excel программаар санхүүгийн тайланг гаргасан зэрэг нь тооцооллын болон нягтлан бодох бүртгэлийн алдаа гарах өндөр эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд нийт 395.4 сая төгрөгийн 32 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 354.5 сая төгрөгийн 24 мэдээллийг ил тод, бүрэн байршуулж, 40.8 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.3.6, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Үдийн хоолны норматив тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлээгүй нь уг тогтоолын холбогдох заалттай нийцсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайланд авлагын данстай холбоотой, төсвийн төлөвлөлт, зарцуулалтай холбоотой, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар нийт 3 зөвлөмж өгч, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж биелээгүй давтан гаргасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитын цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллах нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 333.7 сая төгрөгийн алдаа илэрснээс 15.4 сая төгрөгийн алдааг залруулж, 277.5 сая төгрөгийн алдааг залруулаагүй болно. Залруулаагүй алдааны нийлбэр дүн 2021 оны  санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 78.4 хувьд хүрч материаллаг байдлын түвшингээс давсан байна.  Шилэн дансны 40.8 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар мөнгөн гүйлгээ болон санхүүгийн үр дүнгийн тайланг 15.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг  залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд 40.8 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.3.6, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай нийцэхгүй байна

Иймд гарсан зөрчлийг дахин давтахгүй байх, Шилэн дансны тухай хууль тогтоомжийг мөрдөж  ажиллах албан шаардлага өгсөн.

### 4.3 Залруулаагүй алдаа

- Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн байдлын тайлантай өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн нийт 2.7 ая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд машин тоног төхөөрөмжийн эцсийн үлдэгдлийг - 2.0 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэйгээр илэрхийлсэн.

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тусламж санхүүжилтийн орлого, мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 264.0 сая төгрөгөөр зөрсөн, шалгагдагч байгууллага төсвөөс авах авлага, өглөг байхгүй, төсвийн санхүүжилтийн нийт орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогын нийлбэр нь мөнгөн гүйлгээний тайлангийн тусламж санхүүжилтийн орлогоос 10.0 сая төгрөгөөр зөрсөн, орон нутгийн төсвийн санхүүжилт төсвийн тайланд 0.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн орлого зарлагын ангиллыг зөрүүлсэн зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын алдаа зөрчил түгээмэл байгааг залруулах боломжгүй байна. Залруулаагүй алдааны нийлбэр дүн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 78.4 хувьд хүрч материаллаг байдлын түвшингээс давсан байна.
- Шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл хөтөлсөн санхүүгийн программ эвдэрсэн гэсэн тайлбарыг 2021 оны 1 сараас эхлэн тавьж санхүүгийн тайланг ирүүлэлгүй хамгийн сүүлийн өдөр тайлангаа хянуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан БАЙГУУЛЛАГЫН НЭР | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Залруулаагүй алдаа | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэг | 7 | 333.7 | 1 | 15.4 | 5 | 277.5 | 1 | 40.8 | 0 | 0 |